

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН**

ИЛТГЭХ ХУУДАС

Дотоод хяналт шалгалт хийсэн тухай

2023 оны 12 дугаар сарын 20

Номгон

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналт, шалгалтын нэгжийн 2023 оны төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлийн дагуу хяналт шалгалтыг хийллээ.

Нэг. Байгууллагын ажилчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр ажилчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөлийн гишүүн Б.Биндэрьяа хяналт шалгалт хийллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр Тамгын газрын даргын 2018 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан. Тус хөтөлбөрийн зорилго “төрийн албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог сайжруулах асуудлын хүрээнд ажлын байрны нөхцлийг сайжруулах, аж төрөх нийгмийн баталгааг хангах, зэр бүтээлтэй, тогтвортой суурьшилтай ажиллах боломжоор хангах, албан хаагчдын эрүүл мэнд, ажил амралтын зохистой харилцааг тогтоох нөхцлийг бүрдүүлэхэд” оршино гэжээ.

Хөтөлбөрийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр тавьсан зорилтуудын хувьд хууль тогтоомж зөрчиж төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагч байхгүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу зэрэг дэв болон бусад нэмэгдлийг 2022 онд 6, 2023 онд 4 албан хаагч авсан байна.

Төсвийн хэмнэлтээс шалтгаалан тогтвортой суурьшилтай 5-аас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад 2019 оноос хойш дэмжлэг үзүүлээгүй, 0,7 га газар эзэмших хүсэлтэй 80 гаруй албан хаагчдын өргөдлийг Үйлдвэрчний эвлэл хүлээн авч, Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй өдий хүрчээ.

Ажилтан албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд 2023 оны хагас жилийн байдлаар улсын болон байгууллагын өөрийн 212.0 сая төгрөгийн төсвээр орчин үеийн тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгслээр тухай бүр хангаж ажилласан байна.

Амьдрах таатай орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд 2022-2023 онд түлшний хөнгөлөлтөд 33 албан хаагчдад 4.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Эрх толгойлсон эцэг, эхийн хүүхэд тус бүрт 2023 онд хичээлийн шинэ жилээр 8 албан хаагчийн 21 хүүхдэд тус бүр 100.0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Байгууллагын албан хаагчдыг 2021 оноос хойш эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулаагүй, гадаадад эмчлүүлэх шаардлагатай оноштой 2 албан хаагчдад хамтын гэрээнд тусгагдсан дэмжлэг болох 500.000 төгрөгийг тус бүр үзүүлсэн байна.

Ажилтан албан хаагчдаас Удирдлагын академийн мэргэшшийн сургалтуудад 2022-2023 онд 16 суралцаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.

Санал:

- Тогтворт суурьшилтай 5-аас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авах, газартай болох болон бусад дэмжлэг үзүүлэх төсвийг бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулах, эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх;


Хоёр. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, устгалын байдалд дотоод хяналт-шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Э.Батцэцэг хяналт шалгалт хийлзээ.

Тамгын газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмж 49 нэр төрлийн 80 ширхэг, тавилга хэрэгсэл, бусад хангамжийн материал 109 нэр төрлийн 495 ширхэг, нийт 158 нэр төрлийн 575 ширхэг 301.488.200 төгрөгийн үнэтэй хөрөнгүүд нь ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглагдах боломжгүй болсон тул актлуулах саналыг Орон нутгийн өмчийн газарт хуулийн дагуу хургуулж, актлах шийдвэрийг гаргуулсан боловч одоог хүртэл устгал хийгдээгүй байна. Шийдвэрийн дагуу хөрөнгүүдийг байгууллагын хөрөнгө актлах ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор акталж, илтгэх хуудсыг тус зөвлөлд ирүүлэхийг зөвлөв. Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээ нөхсөн 04-44 БНР улсын дугаартай HUMMER, 99-02 БНХ улсын

дугаартай CARAVAN маркийн 2 авто тээврийн хэрэгслийг дүүдлага худалдаагаар худалдан борлуулж, 20.400.000 төгрөгийг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/102 дугаар захирамжаар Lexus-470 маркийн авто машиныг Ороон нутгийн өмчийн газарт балансаас балансад шилжүүлсэн байна. Байгууллагын орлогод авах тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад хангамжийн материал 59 нэр төрлийн 971 ширхэг, 212.049.800 төгрөгийн үнэтэй хөрөнгүүдийн жагсаалтыг гаргаж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлээгүйгээс тоног төхөөрөмж, эд хөрөнгүүдийг Нягтлан бodoх бүртгэлийн программд орлогод авах ажил хүлээгдэж байна.

Засаг даргын Тамгын газар нь 3 складтай бөгөөд 1 склад гадаа, 2 склад дотор байрлаж байна. Дээрх складуудын эмх цэгц, тавилга хэрэгсэл, бусад хангамжийн материалын хадгалалт, хамгаалалт сайн байна.



Гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд хяналт-шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Э.Батцэцэг, Д.Отгонжаргал нар хяналт шалгалт хийсэн.

Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж үйл ажиллагаага явуулж байна. Тус зөвлөл нь 2023 онд хийх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг батлуулаагүй, Нийтлэг үйлчилгээний албаны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заалт болгон тусгаж, хэрэгжүүлж байна. Үүнд:

-Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, аюулгүй ажиллагааны зааварчлагаа өгч, жолооч нарыг албан ажлаар явах бурд баталгаа авч ажилласан ба тайлант онд осол, зөрчилгүй гараагүй.

-Өрөө, тасалгааны цахилгааны болон сүлжээний утаснуудын аюулгүй байдлыг хангаж далдалсан

-Тамгын газрын байрны гадна хэсэгт туузан гэрэл, камерууд суурилуулж, орчны гэрэлтүүлэг, үзэмжийг сайжруулан, цахилгааны монтаж, дотно, гадна гэрэлтүүлэг, цахилгааны шитэд мэргэжлийн байгууллагатай хамтран үзлэг хийж, 1.5 сая төгрөгийн кабель утас, 3.8 сая төгрөгийн гэрэлтүүлгийн хэрэгсэл нийт 5.8 сая төгрөгийн материал хэрэгсэл худалдан авч засварлан аюулгүй байдлыг хангасан байна.

-Тамгын газрын аваарын нөөц хаалга, гарцны хаалган дээр фосфортой "Exit" гэрэлтэгч тэмдэглэгээ хийж, байрлуулсан.

-Тамгын газрын өрөө, тасалгаа танхimuудад галын аюулгүй байдлын 300 ш санамж байрлуулсан.

-Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор Тамгын газрын өрөөнүүдийн цахилгааны байдалд 2 удаа үзлэг шалгалт хийж, дутагдлыг засуулсан байна.

-Засаг даргын Тамгын газар, Төрийн архивын байранд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдвартгүйжүүлэлт 8 удаа, хортон шавьж, мэрэгч устгах ажлыг 2 удаа, өрөө, танхimuудад мөөгөнцөрийн шинжилгээ 1 удаа холбогдох байгуулагуудтай хамтран хийсэн.

-Үйлчилгээний алба хаагчдад нэг загварын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, малгай, бээлийгээр хангажээ.

Цаашид анхаарах асуудал, санал:

1.Байгууллагын хөрөнгө актлах ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор хөрөнгүүдийг акталж, илтгэх хуудсыг тус зөвлөлд ирүүлэх;

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор боловсруулж, батлуулах;

3.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар орлогод авах хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлж шийвэр гаргуулах;

Дөрөв. Байгууллагын худалдан авалт, ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Д.Отгонжаргал, Б.Биндэрьяа нар хяналт шалгалт хийсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 212.099.800 төгрөгийн 59 хөрөнгө худалдан авсан байна. Үүнээс өөрийн төсвийн хөрөнгөөр 5 буюу 46.009.700 төгрөгийн хөрөнгийг орлогод авсан байна. Үүнд:

- Ipad 11 ширхэг нэгжийн үнэ 2.650.000, нийт 29.1500.000 төгрөг
- Зөөврийн компьютер I7 1 ширхэг, үнэ 3.959.700 төгрөг
- Зөөврийн компьютер I5 1 ширхэг, үнэ 3.900.000 төгрөг
- Цахилгаан мотор 2 ширхэг, нэгжийн үнэ 4.500.00, нийт үнэ 9.000.000 төгрөг

Худалдан авах ажиллагаа зарлаж “Дижитал сервис” ХХК-тай албан хэрэгцээнд бичиг хэргийн материал нийлүүлэх 31.241.540 төгрөгийн, Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээнд батлагдсан дээд хэмжээ нь сард 7.500.000 төгрөг, нийт 90.000.000 төгрөгийн гэрээг “НИК” ХХК-тай байгуулан, шатахуун нийлүүлэлт хэвийн явагдаж байна.

Шуудан холбооны төлбөрийг шууд гэрээ байгуулсан байна. Мэдээлэл сурталчилгааны зардалд 6 телевизтэй 36.000.000 төгрөгийн гэрээ байгуулж, хамtran ажиллаж байна.

Байгууллагын 2023 оны нийт батлагдсан төсөв 3.254.319.975 төгрөг бөгөөд хангамж бараа материалын зардалд 173.620.000 төгрөгийг төсөвлөж, зардал тус бүр дээр хуулийн дагуу худалдан авах ажиллагаа болон шууд гэрээг байгуулж, бараа бүтээгдэхүүн ханганд нийлүүлэлт тасралтгүй хийгдэж байна.

Тав. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Э.Батцэцэг, Л.Лхамдулам нар хяналт шалгалт хийлээ.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор байгууллагын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Журмын зорилго нь Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цаашид “Тамгын газар” гэх/ ажлын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны үндсэн зарчмыг

хэрэгжүүлэх, төрийн албан хаагч /цаашид “ажилтан” гэх/ хөдөлмөрийг оновчтой, үр ашигтай зохион байгуулах, төрийн албаны тасралтгүй, шуурхай байдлыг хангах, албан хаагчдын ёс зүй, төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зэрэг хөдөлмөрийн нийтлэг харилцааг зохицуулахад оршиж байна.

1. Тамгын газрын даргын эрх, үүргийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож ажиллаж байна. Тамгын газарт тогтоолын дагуу үндсэн 57 албан хаагч ажиллахаас 55 албан хаагч ажиллаж байна. Гэрээт 29 албан хаагч ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасан үүргийг хүлээн хэрэгжилтийг ханган ажилладаг бөгөөд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчин бүрдүүлж, энэхүү асуудлуудыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж байна. Тайлант онд дээрх асуудалтай холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна.

Ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж 2021 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын эцэг, эхийн зөвлөлийн санаачилгаар НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /КОICA/-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслийн дэмжлэгтэйгээр албан хаагчдын хүүхдүүдийг ая тухтай, амрах, тоглох, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлж хүүхдийн өрөөг байгуулсан байна.

Албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 17 ажил, арга хэмжээ, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 20 ажил, арга хэмжээ тусган төлөвлөж ажилласнаас сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 82.3, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 78 хувьтай байна. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, албан хаагчдын хүүхдийн өрөөг тохижуулах, хэвийн ажиллах нөхцөлөөр хангах зэрэг ажлууд хийгдээгүйгээс хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

2. Нэгжийн даргын эрх, үүргийн хүрээнд:

Нэгжийн дарга нь нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүрэм болон ажилтнуудын ажлын чиг үүрэг, гүйцэтгэлийн тайлан, хугацаатай тайлан мэдээний чанарт хяналт тавьж, арга зүйн зөвлөмжөөр ханган, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага, ёс зүй, ажлын бүтээмж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцаж ажилласан байна.

3. Гүйцэтгэх албан тушаалтны эрх, үүргийн хүрээнд:

Албан хаагч нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийнхээ хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр боловсруулж, хагас бүтэн жилээр тайлагнаж, үнэлүүлж хэвшсэн байна.

Эзэмшиж буй өдөр хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт хамгаалалтыг бүрэн хариуцах ба эвдрэл гэмтэл гарвал тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд мэдэгдэж Тамгын газрын няравт хүлээлгэн өгдөг. Хэрэв өөрийн буруугаас эвдэлсэн тохиолдолд хохирлыг ажилтан бүрэн хариуцаж байна.

4. Байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд:

Тамгын газарт Дотоод хяналтын ажлын хэсэг, Өмч хамгаалах зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Байгууллагын ёс зүйн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Залуучуудын зөвлөл, Тооллогын комисс /хагас, бүтэн жилээр гардаг/ зэрэг орон тооны бус зөвлөл, комиссууд байгууллагын даргын тушаалаар байгуулаадан үүрэг, чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулж байна.

Ажлын цаг 09:00-18:00, цайны цаг 13:00-14:00 цагийн хооронд байхаар, захиргааны санаачилгаар ажлын бус цагаар болон нийтээр амрах амралтын өдөр, баяр ёслол, ажлын онцлогоос шалтгаалан бямба, ням гарагт амраах боломжгүй бол ажилтантай тохиролцож долоо хоногийн өөр дараалсан хоёр өдөр амраахаар дотоод журамд тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Албан хаагчдын саналыг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж, ээлжийн амралтын хуваарийг байгууллагын даргын шийдвэрээр 1 дүгээр улиралд баталж, хуваарийн дагуу амраасан байна. Албан хаагчийн хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзаж байгууллагын дарга 5 хүртэл хоног, нэгжийн дарга 3 хүртэл хоногийн цалинтай чөлөөг жилд 2 удаа олгож, ажил олгогч ажилтанд тодорхой тохиолдолд цалинтай чөлөө олгох зохицуулалтыг байгууллагын хамтын гэрээгээр зохицуулсан.

Тайлант онд 39 албан хаагч цалинтай болон цалингүй чөлөө авсан байна.

Амрах, хооллох завсарлагаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насын хүүхэдтэй буюу нэг хүртэлх насын ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насын, түүнчлэн нэг нас хүрсэн болтөч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгох бөгөөд ажилтны хүсэлтээр хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажлын цагийг бодиносгох хэлбэрээр ажиллуулж, 6 албан хаагч хамрагдсан байна.

Албан хаагчдын цалин хөлсийг сар бүрийн 25-ны өдрийн дотор олгодог бөгөөд ажилтны хүсэлтээр урьдчилгааг сарын үндсэн цалинд багтаан олгож хэвшсэн байна.

5.Хөдөлмөрийн болон эд хөрөнгийн сахилгын хүрээнд:

Албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулдаг бөгөөд 2023 онд сахилгын ноцтой зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч байхгүй байна.

Зургаа. Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Л.Лхамдүлам хяналт шалгалт хийлгээ.

Авлигатай тэмцэх газраас 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/14581 дугаар албан бичгээр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг ирүүлсэн байна. Тус зөвлөмжийг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд хариуцуулан ажилласан байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх 6 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1а/888 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт заасан хугацааны дотор, мөн хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлээгүй албан хаагчдад хариуцлага тооцсон тухай шийдвэрүүдийн хуулбарыг хүргүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газраас 2023 онд шинээр зөвлөмж ирүүлээгүй байна.

Санал:

1. Төрийн албан хаагчид ХАСХОМ гаргах хуулийн хугацаандаа хөрөнгө орлогоо мэдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Долоо. Төрийн аудитын газрын албан шаардлагын хэрэгжилтийн талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан 2023 онд хийх Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүн Ш.Гэрэлсүх хяналт шалгалт хийллээ.


Аймгийн Төрийн аудитын газраас 4 заалт бүхий албан шаардлагыг аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсний хэрэгжилтийн байдалд дотоод хяналт хийхэд албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

1. Баянхонгор сумын 4 дүгээр багийн нэг гудамжийг "Жишиг гудамж" болгох ажлын тендерийг зарлаж гүйцэтгэгчээр "Номгон такс констракшн" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг 2022 оны 08 дугаар сард эхлүүлсэн бөгөөд дутуу ажлыг бүрэн хийлгэн хүлээлцэж, актаар баталгаажуулсан байна.

2. "Баянжаргант хүнс"ХХК,"МЦ Энх"ХХК,"Хонгор инженеринг ХХК-иуд 11505.0 мянган төгрөгийн Е баримтыг нөхөн шивж,төсөвт 1150,5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжийг аудитын явцад барагдуулсан байна.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцад батлагдаж орон нутагт эрх шилжиж ирсэн Баянхонгор аймгийн Баянхонгор суманд нам даралтын зуухнуудад утаа шүүгч суурилуулах ажлын гүйцэтгэгчээр "Түйн хийморь" ХХК-тай 660,000,000 /зургаан зуун жаран сая/ төгрөгөөр гэрээ байгуулж ажлыг 2022 онд эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 8 янданд утаа шүүлтүүр суурилуулхаар төлөвлөсөн бөгөөд одоогийн байдлаар "Зүүн шанд" ХХК, "РМБ" ХХК-ийн зуухны яндангуудад суурилуулан 40%-ийн санхүүжилт буюу 258,108,4 мянган төгрөгийн гүйцэтгэл авсан. Үлдэгдэл ажлыг 2024 онд хийхээр гэрээг сунган, гүйцэтгэлээр санхүүжүүлэн ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

4. Шилэн дансны цахим сайтад тогтмол зардлын болон ажил гүйцэтгэх гэрээ, бусад худалдан авалттай холбоотой гэрээг байршуулаагүй, мөн 6 мэдээг хугацаа хоцроосон байдлыг засаж,тухай бүр зохих мэдээллийг хугацаанд нь байршуулж,мэдээг хугацаанд нь өгөх асуудал тогтмолжсон байна.

ХЯНАСАН:
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА 
ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН  Б.БИНДЭРЬЯА